



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2022 оны 09 сарын 08 өдөр

Дугаар 355

Улаанбаатар хот

Төрийн өмчид эд хөрөнгө бүртгэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.10, 5.1 дэх заалт, Увс аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2022 оны 7/09 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Увс аймгийн өмчөөс шилжүүлсэн 22,338,697.00 (хорин хоёр сая гурван зуун гучин найман мянга зургаан зуун ерэн долоон) төгрөгийн балансын үнэ, 1,122,883.03 (нэг сая нэг зуун хорин хоёр мянга найман зуун наян гурван төгрөг гурван мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг төрийн өмчид хүлээн авч Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Увс аймгийн Онцгой байдлын газарт эзэмшүүлж үндсэн хөрөнгөд бүртгэхийг, зөвшөөрсүгэй.

2. Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Хошууч генерал Г.Ариунбуян, Увс аймгийн Онцгой байдлын газрын дарга, хурандаа Б.Баттулга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Комисс томилон хөрөнгө хүлээн авч, бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132002684

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны 09 дугаар сарын 08-ны өдрийн
... дугаар тогтоолын хавсралт

УВС АЙМГИЙН ӨМЧӨӨС ТӨРИЙН ӨМЧИД ХҮЛЭЭН АВЧ УВС АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН
ГАЗАРТ ЭЗЭМШҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААТ

д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
Барилга байгууламж							
1	Давст сумын Соёлын төвийн Клубын барилга	1957	ш	1	21,850,697.00	1,122,883.03	20,727,813.97
2	Газар эзэмших эрх (Давст сум 2-р багт байрлах Клубын барилгын газар)	2017	м.кв	244м2	488,000.00		488,000.00
					22,338,697.00	1,122,883.03	21,215,813.97
Нийт дүн					(хорин хоёр сая гурван зуун гучин мянга зургаан зуун ерэн долоон төгрөг)	(нэг сая нэг зуун хорин хоёр мянга найман зуун наян гурван төгрөг гурван мөнгө)	(хорин нэгэн сая хоёр зуун арван таван мянга найман зуун арван гурван төгрөн ерэн долоон мөнгө)